



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/58

Бат-Өлзий сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэг, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2023 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 1/49 дүгээр зөвлөмжийг үндэслэн Сумын төвд цамхагт гэрэлтүүлэг болон бусад гэрэлтүүлэг нэмэгдүүлэх, гэрэлтүүлэг засварын ажлын тендерийг 78,881,966 (далан найман сая найман зуун наян нэгэн мянга есөн зуун жаран зургаан) төгрөгөөр "Оджи-Од" хязгаарлагдмал хариуцлагатай компаниар гүйцэтгүүлсүгэй.
2. Тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулж, ажлын явцад хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.
3. Зардалд шаардагдах 78,881,966 (далан найман сая найман зуун наян нэгэн мянга есөн зуун жаран зургаан) төгрөгийг гэрээний дагуу, Орон нутгийн хөгжлийн сангийн бусад хөрөнгө данснаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.
4. Шалгарсан аж ахуйн нэгж санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн авч гэрээний дагуу санхүүжилт өгөхийг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

